

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## УЛС БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛД ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР  
ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН 7.2  
ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГИЙН ҮР ӨГӨӨЖ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

**АУДИТЫН КОД: : ХӨА-2025/06-21-ШТА-ГА**

Хөвсгөл аймаг  
2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх  
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [Tegshdelgerb@audit.gov.mn](mailto:Tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 91890258 Цахим хаяг: [Davaadorjz@audit.gov.mn](mailto:Davaadorjz@audit.gov.mn)

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: [gurbazarn@audit.gov.mn](mailto:gurbazarn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу.  
[https://audit.mn/?page\\_id=579](https://audit.mn/?page_id=579)

## АГУУЛГА

### Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь  
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

З.Даваадорж

Аудитор

Н.Гүрбазар

Аудитын тайлан,  
дүгнэлттэй холбоотой  
асуудлаар нэмж тодруулах,  
асууж лавлах зүйл гарвал  
70384043 дугаарын утас,  
70383793 дугаарын  
факсаар харилцана уу.

**ХАЯГ:** Мөрөн сум Аймгийн  
ЗДТГ-ын “А” корпус 3  
давхар

**Цахим хаяг:**

[audit.mn/?page\\_id=579](http://audit.mn/?page_id=579)

**2025 оны 04 дүгээр сар**

### Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

**Бүлэг А. Сүүлийн 5 жилд хэрэгжсэн 11.7 тэрбум төгрөгийн 118 төсөл арга хэмжээний 52 хувь буюу 6.2 тэрбум төгрөгийн 61 төсөл, арга хэмжээ өмчлөлд бүртгэх боломжгүй, 9.3 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ үр өгөөжгүй хөрөнгө оруулалт болсон байна.**

А.1. Хөрөнгө оруулалтыг хууль журамд нийцүүлэн төлөвлөхгүй байгаагаас шалтгаалан зарим төсөл, арга хэмжээний үр өгөөжид сөрөг нөлөө үзүүлж байна.

А.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

А.3. Барилга, байгууламжид хийсэн зарим засварын ажлыг УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

А.4 Сүүлийн 5 жилд хэрэгжсэн 11.7 тэрбум төгрөгийн 118 төсөл арга хэмжээний 52 хувь буюу 6.2 тэрбум төгрөгийн 61 төсөл, арга хэмжээ өмчлөлд бүртгэх боломжгүй, 9.3 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ үр өгөөжгүй хөрөнгө оруулалт болсон байна.

**Бүлэг Б: Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шалгуурыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажилласан байна.**

Б.1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын захиалагч нь тендер шалгаруулалтын баримт бичгийг баталгаажуулж ажиллаагүй байна.

Б.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна.

**Бүлэг В: Аудитын шийдвэрийн хэрэгжилт, барилга байгууламж засварын ажлын бүх талын хяналтын үр нөлөөг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага үүссэн байна.**

В.1. Барилга байгууламж, засварын ажлын бүх талын хяналтын үр нөлөөг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага үүссэн байна

В.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Тайлангийн хавсралтууд

Холбогдох байгууллагуудын санал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/13

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагуудыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Мөрөн сумын Засаг дарга нарт хүргүүлсүгэй.

3. “Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-нийцлийн аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлтийг 2025 оны 12 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга (Д.Пүрэвдорж), аймгийн Засаг дарга (Л.Төмөрбаатар), аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Базардамбуу), Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Бэхбаяр), Худалдан авах ажиллагааны газрын дарга (Э.Аззаяа), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал (Д.Батчулуун), Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Л.Баярхүү), Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр) даалгасугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 05 дугаар сарын 05-ний өдрийн 4/13 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт нийцлийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

| д/д | Акт, албан шаардлагын утга | Хариуцах байгууллага                         | Акт, албан шаардлагын дугаар      |
|-----|----------------------------|----------------------------------------------|-----------------------------------|
| 1   | Зөрчил арилгах тухай       | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад | 87/A2270438/ХӨА-2025/06-21-ШТА-ГА |
| 2   | Зөрчил арилгах тухай       | Аймгийн Засаг даргад                         | 88/A2270438/ХӨА-2025/06-21-ШТА-ГА |

--ooOoo--

## Товчилсон үгийн тайлбар

|        |                                                       |
|--------|-------------------------------------------------------|
| АИТХ   | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                  |
| АЗД    | Аймгийн Засаг дарга                                   |
| ҮАГ    | Үндэсний аудитын газар                                |
| ХӨТАГ  | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар               |
| ЗДТГ   | Засаг даргын Тамгын газар                             |
| ХБТХОХ | Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| ХШҮХ   | Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс                   |
| СХДАА  | Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба                |
| ОНӨГ   | Орон нутгийн өмчийн газар                             |
| ХААГ   | Худалдан авах ажиллагааны газар                       |
| НТШ    | Нээлттэй тендер шалгаруулалт                          |
| ТЕЗ    | Төсвийн ерөнхийлөн захирагч                           |
| ТЭЗҮ   | Техник, эдийн засгийн үндэслэл                        |
| ТАХ    | Төсөл, арга хэмжээ                                    |

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:



## **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар дугаар тогтоол, МҮЕА-ын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 108 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

## **Аудитын зорилт:**

“Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хууль журамд заасны дагуу төлөвлөж, үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх,
- ❖ Хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх,
- ❖ Өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлж хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх.

## **Аудитын хамарсан хүрээ:**

Аудитад Хөвсгөл аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө болон Мөрөн сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хамруулж аймаг, сумдын нийт хөрөнгө оруулалтад зарцуулахаар баталсан санхүүжилтийн 90 хувьд гүйцэтгэж, хөрөнгө оруулалт/их засвар/-ыг хэрэгжүүлсэн аймгийн Засаг дарга, Мөрөн сумын Засаг дарга аймгийн ЗДТГ, Мөрөн сумын ЗДТГ, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, гүйцэтгэгч аж ахуй нэгж болон хяналтын чиг үүрэг бүхий Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Арбулаг, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул, Цагааннуур, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Түнэл, Мөрөн сумд болон Хатгал тосгоны холбогдох төрийн байгууллага, ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт хийсэн.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хийх хяналтыг 6,296.5 сая төгрөгийн 48 төсөл, арга хэмжээнд буюу нийт төсөвт өртгийн 80 хувьд гүйцэтгэсэн.

## **Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Хөвсгөл аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний

харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд үндэслэн аудитын дүгнэлт, шийдвэрийг боловсрууллаа.

**Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:**

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Н.Гүрбазар нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

**Материаллаг байдал:**

Төлөвлөлтийн шатанд 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт эзлэх хувь, санхүүжих дүн бага байгааг харгалзан материаллаг байдлын түвшнийг өндрөөр буюу санхүүжих дүнгийн 2 хувь 85.6 сая төгрөгөөр тооцсон.

Аудитаар материаллаг байдлыг тооцохдоо дараах хүчин зүйлсийг шалгуур болгон авч үзсэн. Үүнд:

1. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь чанартай гүйцэтгээгүйгээс төсвөөс үргүй зардал гарах, төслийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө алдагдах,
2. Төсөл, арга хэмжээний хяналт сул байснаас хөрөнгө чанаргүй, ашиглалтын шаардлага хангалтгүй байх
3. Төсөл, арга хэмжээг ТЕЗ-ын саналд үндэслээгүй, урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулаагүй төлөвлөсөн байх
4. Төсөл, арга хэмжээний ашиглалтын зардал, хүний нөөцийг тооцож төлөвлөөгүй байх
5. Аливаа залилан болон ашиг сонирхлын зөрчилтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байх.

**Хүндрэл бэрхшээл:**

Аудитыг гүйцэтгэхэд хүндрэл бэрхшээл учраагүй.

**Ерөнхий мэдээлэл:**

**Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын ерөнхий мэдээлэл:**

Хөвсгөл аймгийн 2024 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 04 дугаар тогтоолоор баталж, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 8,122.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 5,080.0 сая төгрөгөөр санхүүжих 47 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Аймгийн 2024 оны төсөвт ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн XXVIII/37 дугаар тогтоолоор тодотгол хийж дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна. Үүнд:

*Хүснэгт №1 /сая төгрөгөөр/*

| д/д | Төсвийн тодотгол орсон төсөл, арга хэмжээний нэр     | Төсөвт өртөг | Төсөвт өртөгт хийсэн тодотгол |        |                | Санхүүжих дүн | Санхүүжилтэд хийсэн тодотгол |        |                |
|-----|------------------------------------------------------|--------------|-------------------------------|--------|----------------|---------------|------------------------------|--------|----------------|
|     |                                                      |              | Нэмсэн                        | Хассан | Тодотгосон дүн |               | Нэмсэн                       | Хассан | Тодотгосон дүн |
| 1   | Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засвар         | 1,037.4      | -                             | -      | 1,037.4        | 374.9         | -                            | 358.5  | 16.4           |
| 2   | Спорт заалны засвар /Цагаан-Үүр сум/                 | 80.0         | -                             | 80.0   | -              | 80.0          | -                            | 80.0   | -              |
| 3   | Хөгжимт драмын театрын дотор засвар                  | 100.0        | -                             | 100.0  | -              | 100.0         | -                            | 100.0  | -              |
| 4   | Хүүхдийн цэцэрлэгийн дээврийн засвар /Шинэ-Идэр сум/ | 150.0        | -                             | 150.0  | -              | 150.0         | -                            | 150.0  | -              |
| 5   | Соёлын төвийн дээврийн засвар /Төмөрбулаг сум/       | 100.0        | -                             | -      | 100.0          | 100.0         | -                            | 94.0   | 6.0            |
| 6   | Урандөш" хүүхдийн зуслангийн байруудын их засвар     | 188.0        | 400.0                         | -      | 588.0          | 188.0         | -                            | 156.0  | 32.0           |

|                                  |                                                                |                |              |              |                |                |              |                |              |
|----------------------------------|----------------------------------------------------------------|----------------|--------------|--------------|----------------|----------------|--------------|----------------|--------------|
| 7                                | 50 хүүхдийн ортой дотуур байрны засвар /Түнэл сум/             | 100.0          | -            | -            | 100.0          | 100.0          |              | 77.5           | 22.5         |
| 8                                | Соёлын төвийн засвар/Тосонцэнгэл сум/                          | 200.0          | 50.0         | -            | 250.0          | 200.0          | 50.0         | -              | 250.0        |
| 9                                | Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн биеийн тамирын талбайн засвар | 216.8          | 20           | -            | 236.8          | 120.0          | -            | -              | 120.0        |
| 10                               | Спорт заалны засвар /Хатгал тосгон/                            | 100.0          | 79.6         | -            | 179.6          | 100.0          | -            | -              | 100.0        |
|                                  | <b>Нийт тодотгосон дүн</b>                                     | <b>2,272.2</b> | <b>549.6</b> | <b>330.0</b> | <b>2,491.8</b> | <b>1,512.9</b> | <b>50.0</b>  | <b>1,016.0</b> | <b>546.9</b> |
| <b>Тодотголоор шинээр нэмсэн</b> |                                                                |                |              |              |                |                |              |                |              |
| 11                               | Уурын зуухны тогоо худалдаж авах /Шинэ-Идэр сум/               | 168.0          | 168.0        | -            | 168.0          | 168.0          | 168.0        | -              | 168.0        |
|                                  | <b>Нийт</b>                                                    | <b>2,440.2</b> | <b>717.6</b> | <b>330.0</b> | <b>2,659.8</b> | <b>1,680.9</b> | <b>218.0</b> | <b>1,016.0</b> | <b>714.9</b> |

Хүснэгтэд үзүүлснээр 2024 онд хөрөнгө оруулалтад зарцуулах 686.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хасаж, 330.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг зогсоож, 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 50.0 сая төгрөгөөр нэмж, 168.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр нэмсэн бол 4 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 549.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн тодотголоор 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8,510.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 45 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тогтоосон байна. /Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт №1-ээс харна уу/

Тайлант онд баталсан хөрөнгө оруулалтын төрлийг төсөвт өртөг, санхүүжилтийн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №2 /сая төгрөгөөр/


| Хөрөнгө оруулалтын төрөл | Тоо       | Төсөвт өртөг   | 2024 оны санхүүжилт | Төсөвт өртөгт эзлэх хувь | Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний |                | Шилжих ТАХ-ний |                |
|--------------------------|-----------|----------------|---------------------|--------------------------|----------------------------|----------------|----------------|----------------|
|                          |           |                |                     |                          | Тоо                        | Төсөвт өртөг   | Тоо            | Төсөвт өртөг   |
| Барилга, байгууламж      | 5         | 2,249.9        | 796.1               | 35.4%                    | -                          | -              | 5              | 2,249.9        |
| Засвар                   | 30        | 5,627.0        | 3,072.8             | 54.6%                    | 26                         | 3,794.6        | 4              | 1,832.4        |
| Тоног төхөөрөмж          | 10        | 633.6          | 413.2               | 65.2%                    | 8                          | 338.8          | 2              | 294.8          |
| <b>Нийт</b>              | <b>45</b> | <b>8,510.4</b> | <b>4,282.1</b>      | <b>50,3%</b>             | <b>34</b>                  | <b>4.133.4</b> | <b>11</b>      | <b>4,377.0</b> |

Тайлант онд шинээр хэрэгжих 34 төсөл, арга хэмжээнд 3,000.1 сая төгрөгийн, шилжих 11 төсөл, арга хэмжээнд 1,282.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөвт өртөг, баталсан санхүүжилтийг салбар, салбарын 2024 оны санхүүжилтэд эзлэх хувийг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График №1/сая төгрөгөөр/





Графикт үзүүлснээр боловсролын салбарт хамгийн их хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

### Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтын ерөнхий мэдээлэл:

Мөрөн сумын 2024 оны төсвийг Мөрөн сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 03 дугаар тогтоолоор баталж, тогтоолын 3 дугаар хавсралтаар 1,696.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,536.8 сая төгрөгөөр санхүүжих 25 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тогтоосон байна.

Мөрөн сумын төсөвт 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр тодотгол оруулж дараах байдлаар төсвийн зохицуулалт хийсэн байна.

Хүснэгт №3 /сая төгрөгөөр/

| Д/д                       | Төсвийн тодотгол орсон төсөл, арга хэмжээний тоо | Төсөвт өртөг | Төсөвт өртөгт хийсэн тодотгол |        |                | Санхүүжих дүн | Санхүүжилтэд хийсэн тодотгол |        |                |
|---------------------------|--------------------------------------------------|--------------|-------------------------------|--------|----------------|---------------|------------------------------|--------|----------------|
|                           |                                                  |              | Нэмсэн                        | Хассан | Тодотгосон дүн |               | Нэмсэн                       | Хассан | Тодотгосон дүн |
| 1                         | 2                                                | 181.5        |                               | 181.5  | -              | 107.5         | -                            | 107.5  | -              |
| 2                         | 5                                                | 356.0        | -                             | 119.0  | 237.0          | 356.0         | -                            | 119.0  | 237.0          |
| 3                         | 4                                                | 370.4        | 112.0                         | -      | 482.4          | 370.4         | 112.0                        | -      | 482.4          |
| Дүн                       | 11                                               | 907.9        | 293.5                         | 300.5  | 719.4          | 833.9         | 112.0                        | 226.5  | 719.4          |
| Тодотголоор шинээр нэмсэн |                                                  |              |                               |        |                |               |                              |        |                |
| 4                         | 15                                               | 269.5        | 269.5                         | -      | 269.5          | 269.5         | 269.5                        | -      | 269.5          |
| Нийт                      | 26                                               | 1,117.4      | 563.0                         | 300.5  | 988.9          | 1,103.4       | 381.5                        | 226.5  | 988.9          |

Хүснэгтэд үзүүлснээр нийт 26 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, болон санхүүжилтэд зохицуулалт хийж 181.5 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг 107.5 сая төгрөгийн санхүүжилтийн хамт зогсоож, 5 төсөл, арга хэмжээний 119.0 сая төгрөгийн санхүүжилтийг хассан бол 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 112.0 сая төгрөгөөр нэмж, 381.5 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр нэмсэн байна.

Төсвийн тодотголоор Мөрөн суманд 1,777.9 төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тогтоосон байна.

Үүнээс 1,333.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ баталсан байна. /Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт №2-оос харна уу/

Мөрөн сумын 2024 онд хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалтын төрлийг төсөвт өртөг, санхүүжилтийн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.


Хүснэгт №4 /сая төгрөгөөр/

| Хөрөнгө оруулалтын төрөл | Тоо | Төсөвт өртөг | 2024 онд баталсан санхүүжилт | Төсөвт өртөгт эзлэх хувь | Шилжих хөрөнгө оруулалтын |              |
|--------------------------|-----|--------------|------------------------------|--------------------------|---------------------------|--------------|
|                          |     |              |                              |                          | Тоо                       | Төсөвт өртөг |
| Барилга, байгууламж      | 15  | 1,077.0      | 991.0                        | 92.0%                    | 3                         | 444.2        |
| Их засвар                | 8   | 189.6        | 189.6                        | 100%                     | -                         | -            |
| Тоног төхөөрөмж          | 14  | 339.5        | 339.5                        | 100%                     | -                         | -            |
| ТЭЗҮ                     | 2   | 171.8        | 171.8                        | 100%                     | -                         | -            |
| Дүн                      | 39  | 1,777.9      | 1,691.9                      | 95.1%                    | 3                         | 444.2        |

Өмнөх оноос шилжих 3 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 358.1 сая төгрөгийг тайлант онд баталсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөвт өртөг, баталсан санхүүжилтийг салбар, салбарын хөрөнгө оруулалтын 2024 оны санхүүжилтэд эзлэх хувийг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График №2 /сая төгрөгөөр/



Графикаас үзэхэд дэд, бүтэц/хот байгуулалт/-ийн салбарт хамгийн их хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

БҮЛЭГ А:

Сүүлийн 5 жилд хэрэгжсэн 11.7 тэрбум төгрөгийн 118 төсөл арга хэмжээний 52 хувь нь өмчлөлд бүртгэх боломжгүй, 9.3 хувь нь үр өгөөжгүй хөрөнгө оруулалт болсон байна.


**А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох хууль журамд нийцүүлэн төлөвлөхгүй байгаа байдал давтагдсаар байна.**

**Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт тухайд:**

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжих 4,133.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээ баталсан байна.

Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд нь Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон аймгийн дунд хугацааны бодлого Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцэж байгаа боловч жилийн хөгжлийн төлөвлөгөөнд нийцээгүй, Төсвийн тухай хууль, Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлээгүй, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу төлөвлөлтийн баримт бичгийг бүрдүүлээгүйн дээр дараах шаардлагуудыг хангуулаагүй байна. /Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт №3-аас харна уу/ Үүнийг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График №3 /сая төгрөгөөр/



Графикаас үзэхэд: 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүдийн 0.7 хувь нь өмчлөлд бүртгэх боломжгүй, 8.0 хувь нь техникийн тодорхойлолт, ажлын даалгаваргүй, 51.5 хувь нь хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, 61.1 хувь нь зураг, төсөвгүй, 26.7 хувь нь Хөвсгөл аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд нийцээгүй төсөл, арга хэмжээнүүд байгаа бол **нийт хөрөнгө оруулалтыг олон нийтээр хэлэлцүүлээгүй** байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29, 29<sup>11</sup> дүгээр зүйлд заасан хуулийн шаардлагад нийцээгүй байна.

<sup>1</sup> 29<sup>1</sup>.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

29<sup>1</sup>.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх:

29<sup>1</sup>.2.1.тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

29<sup>1</sup>.2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

29<sup>1</sup>.2.3.техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх;

29<sup>1</sup>.2.4.урсгал зардал төслийн урсгал зардлыг тооцсон байх;

29<sup>1</sup>.2.5.тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх.

29<sup>1</sup>.2.6.олон нийтээр хэлэлцүүлсэн байх.

29.2.Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

Төлөвлөлтийн шатанд төсөл, арга хэмжээний зураг, төсөв, ажлын иж бүрэн байдалд хяналт хэрэгжүүлэхгүй байгаагаас 273.3 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд дараах сөрөг үр дагаврыг үүсгэсэн байна. Үүнд:

1. Өнөших трейд ХХК-ийн 114.3 сая төгрөгөөр гүйцэтгэсэн аймгийн Нэгдсэн эмнэлгийн угаалгын байрны их засварын ажлыг төлөвлөхдөө дулаалга, агааржуулалтын ажлыг давхар шийдвэрлэж өгөөгүйгээс засвар хийсэн барилгын дотор хана мөөгөнцөртөх, эмульс, будаг нь хуурч унасан байдалтай байна.



Нэгдсэн эмнэлгийн угаалгын байрны мөөгөнцөр үүсэж, будаг нь хуурсан байдал

2. Баяндэ ХХК-ийн 159.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн 640 хүүхдийн сургуулийн дээврийн засвар /Сод-эрдэм/-ын зураг, төсвийг зохиолгож, батлахдаа дээврийн агааржуулалтыг дутуу тооцоолж, агааржуулалтын цөөн хоолойтой хийсэн нь дотоод агаар гадагшлахгүй эвгүй үнэр буцаж орж ирдэг нөхцөл байдалтай болсон байна.

Зураг төсөвт хяналт хийж, хийгдэх ажлыг бүрэн төлөвлөөгүй нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.4<sup>2</sup>-т гэж заасан чиг үүргээ бүрэн биелүүлээгүйгээс шалтгаалан гарсан байна.

Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ төлөвлөн баталснаас шалтгаалан төсөв баталснаас хойш хийсэн зураг, төсөвт нийцүүлэн 4 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 549.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Үүнд:

- “Урандөш” хүүхдийн зуслангийн байруудын их засварын ажлын төсөвт өртгийг 400.0 сая төгрөгөөр,
- Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн хөл бөмбөгийн талбайн засварын ажлын төсөвт өртгийг 20.0 сая төгрөгөөр,
- Спорт заалны засвар /Хатгал тосгон/-ын ажлын төсөвт өртгийг 79.6 сая төгрөгөөр.
- Соёлын төвийн засвар /Тосонцэнгэл сум/ -ын ажлын төсөвт өртгийг 50.0 сая төгрөгөөр тус тус нэмсэн байна.

Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг үндэслэлгүй тогтоож, дараа нь тодотгол хийж өөрчлөлт оруулж байгаа нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхөөс гадна, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.4<sup>3</sup>-т нийцэхгүй байна.

### **Мөрөн сумын хөрөнгө оруулалтын тухайд:**

29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

<sup>2</sup> “Их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөл, арга хэмжээнд дараах шаардлагыг тавина: тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх.”

<sup>3</sup> Их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөл, арга хэмжээнд дараах шаардлагыг тавина: тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх

Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх 1,333.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл, арга хэмжээг баталсан байна.

Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 36 төсөл, арга хэмжээг Хөвсгөл аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Мөрөн сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн төлөвлөсөн байна.

Төсөл, арга хэмжээнүүдийг холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлсэн эсэхийг хянахад дараах зөрчлүүд илэрч байна.Үүнд:

1. Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг бүрдүүлээгүйн дээр дараах шаардлагуудыг хангуулаагүй байна. /Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт №4-өөс харна уу./ Үүнийг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График №4 /сая төгрөгөөр/



Графикаас харахад шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүдийн 63 хувь нь батлагдсан зураг төсөвгүй, 80 хувь нь хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, 8.3 хувь нь өмчлөлд бүртгэх боломжгүй төсөл, арга хэмжээнүүд байгаа бол **нийт төсөл, арга хэмжээг олон нийтээр хэлэлцүүлээгүй** буюу Төсвийн тухай хуулийн 29, 29<sup>1</sup> дүгээр зүйлд заасан хуулийн шаардлагад шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд нийцээгүй байна.

Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтад хяналт хийх явцад хөрөнгө оруулалтаар бий болох хөрөнгийн урсгал зардал, хадгалалт, хамгаалалтыг төлөвлөөгүйгээс 313.7 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгүүд эвдэрч гэмтсэн байдалтай байна. Тухайлбал:

1. Жигүүр ой ХХК-ийн гүйцэтгэсэн 274.2 сая төгрөгийн 9, 12 дугаар хорооны босоо тэнхлэгийн авто замын дагуу ногоон байгууламж, хашаа хайс, усалгааны систем төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хашаа хайс 15 хэсэг газарт эвдэрч унасан байдалтай байна.



Зам дагуу хийсэн ногоон байгууламжийн хашаа хайс эвдэрч гэмтсэн байдал

2. Хөвсгөл хүрмэн ХХК-ийн гүйцэтгэсэн 39.5 сая төгрөгийн 14 дүгээр багийн цэцэрлэгт хүрээлэнгийн засварын ажил төсөл, арга хэмжээ нь үр дүнд хүрээгүй, засвар хийсэн хөл бөмбөгийн талбайн зүлэг урагдаж, тарсан байдалтай байна.





14 дүгээр багийн цэцэрлэгт хүрээлэнгийн хөл бөмбөгийн талбайн хиймэл зүлэг урагдаж гэмтсэн байдал

Дээрх зөрчлүүдээс үзэхэд өмнөх онд гүйцэтгэсэн аудитаар аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргад өгсөн төсөл, арга хэмжээг төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн төлөвлөж, шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хэлэлцэн батлах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, нийт хөрөнгө оруулалтыг хууль, журамд нийцүүлэн төлөвлөхгүй, зураг, төсөв, ажлын иж бүрэн байдалд хяналт хийхгүй байгаа нь төсөл, арга хэмжээний үр дүнд сөргөөр нөлөөлж, төсвийн үр ашгийг бууруулж байна.

## **А.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.**

### **Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:**

Тайлант онд олгохоор баталсан 45 төсөл, арга хэмжээний 4,282.4 сая төгрөгийн санхүүжилтээс 41 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 3,601.6 сая төгрөгийг олгож санхүүжилтийн гүйцэтгэл 84 хувьтай, 30 төсөл, арга хэмжээ хэрэгжиж нийт төсөл, арга хэмжээнүүдийн 67 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна. /Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд олгосон санхүүжилт, гүйцэтгэлийн хувийг хавсралт №5-аас харна уу/ Энэ нь өмнөх оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлээс 22 хувиар буурсан үзүүлэлт болж байна.

Дараа онд шилжсэн 680.5 сая төгрөгөөс санхүүжилтээс тайлант онд санхүүжилтээ бүрэн аваагүй 6 төсөл, арга хэмжээний 281.6 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

Олгосон санхүүжилтээс 5.8 сая төгрөгийн алданги, 158.2 сая төгрөгийн барьцаа, 57.7 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардал, 28.7 сая төгрөгийн зохиогчийн хяналтын зардлыг тус тус суутган холбогдох дансанд шилжүүлсэн байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

### **Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:**

Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд 39 төсөл, арга хэмжээнд 1,691.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гэрээ байгуулсан 36 төсөл, арга хэмжээнд 1,609.1 сая төгрөгийн санхүүжилт олгож санхүүжилтийн гүйцэтгэл 99.6 хувьтай, 36 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж нийт хөрөнгө оруулалтын 92 хувь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна. /Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд олгосон санхүүжилт, гүйцэтгэлийн хувийг хавсралт №6-аас харна уу/

Хэрэгжээгүй 3 төсөл, арга хэмжээний 42.0 сая төгрөг болон зөвлөх үйлчилгээ төсөл, арга хэмжээний 7.5 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилт дараа онд шилжсэн байна.

Гэрээний дагуу 64.3 сая төгрөгийн барьцаа хөрөнгө, 18.7 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардал, 8.3 сая төгрөгийн зохиогчийн хяналтын зардал суутгасан байна.

Санхүүжилтэд хийсэн хяналтаар 10, 13, 14 дүгээр багуудын гэрлэн хаяг төсөл, арга хэмжээний гэрээнд заасан барьцаа хөрөнгө 0.3 сая төгрөгийг суутгаагүй зөрчил илэрч байна. Зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дээрх зөрчлийг эс тооцвол Мөрөн сумын төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.



Аудитаар илэрсэн 0.3 сая төгрөгийн зөрчлийг эс тооцвол аймгийн төсвийн болон Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

**А.3. Барилга, байгууламжид хийсэн зарим засварын ажлыг УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.**

Тайлант онд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 2,528.9 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ, Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтаас 1,672.0 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан байна.

Үүнээс аймгийн хөрөнгө оруулалтаар бий болсон 6 төсөл, арга хэмжээний 161.5 сая төгрөгийн хөрөнгө, Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтын 33 төсөл, арга хэмжээний 1,499.0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон дараах хөрөнгө, их засварын ажлыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

**Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:**

1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 440.5 сая төгрөгийн хөрөнгийг өмчид бүртгүүлээгүй байна. Үүнд:
  1. Эрүүл мэндийн төв, Спорт заалны сантехник тавих, засвар хийх /Бүрэнтогтох сум, Бүрэн-хаан баг/261.6 сая төгрөг/,
  2. Ногоон байгууламжийн хашаа хайс засварлах /Мөрөн сум 14-р баг/ 19.9 сая төгрөг/,
  3. Мөрөн сумын 640 хүүхдийн сургуулийн дээврийн засвар /159.0 сая төгрөг/.
2. УСНББОУС-ын дагуу капиталжуулах ажлыг 1,004.7 сая төгрөгийн 7 засварын ажилд зохион байгуулаагүй байна. Үүнд:
  1. Ерөнхий боловсролын бага сургуулийн засвар, дулаалга хийлгэх /Хатгал тосгон/ 114.4 сая төгрөг/,
  2. Хүүхдийн цэцэрлэгийн барилгын дулаалга, сангийн засвар /Хатгал тосгон/197.0 сая төгрөг/,
  3. Хүүхдийн цэцэрлэгийн барилгын дулаалга засвар /Арбулаг сум/98.8 сая төгрөг/,
  4. Хүүхдийн цэцэрлэгийн засвар /Могойн гол баг/72.6 сая төгрөг/,
  5. Сумын эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Цагааннуур сум/29.9 сая төгрөг/,
  6. Биеийн тамир, спортын газрын заалны их засвар /Биеийн тамир спортын газар/ 292.3 сая төгрөг/,
  7. Музей, Номын сангийн байрны сантехникийн засвар /Музей, Номын сан/199.5 сая төгрөг/.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байгаа нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.5.1<sup>4</sup>, 5.5.2<sup>5</sup> дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалтад хяналт хийхэд 116.2 сая төгрөгийн үнэ бүхий дараах 2 төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг одоог хүртэл зориулалтын дагуу ашиглаагүй байна. Үүнд:

<sup>4</sup> 5.5.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ;

<sup>5</sup> 5.5.2 “Энэ журмын 5.5.1-д заасан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх чиг үүргийг захиалагчийн өмчийн асуудал хариуцсан нэгж (ажилтан) хэрэгжүүлэх бөгөөд өмчид бүртгүүлэхийг тодорхойлох урьдчилсан маягтыг бөглөн цахим системээр гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтэд хамт ирүүлж, цахим системийн өмчийн санд мэдээллийн санг бүрдүүлнэ;”

1. Мөрөн сумын ЗДТГ-т Зээш гарден ХХК-ийн 2022 онд нийлүүлсэн 96.2 сая төгрөгийн үнэ бүхий Хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмж нь зах зээлийн үнээс хэт өндөр үнээр нийлүүлэгдсэн тул түрээслэх болон худалдан авах боломжтой иргэн, аж ахуйн нэгж олдохгүй, одоог хүртэл ашиглаагүй байна.
2. Улаан-Уул сумын ЗДТГ-т Тоом хангай ХХК -ийн 2024 онд нийлүүлсэн 20.0 сая төгрөгийн үнэ бүхий Байгалийн боржин чулууг зөв хэлбэрт оруулах багаж тоног төхөөрөмжийг ямар зориулалтаар аль байгууллага ашиглах нь тодорхойгүй байгаагаас одоог хүртэл ашиглаагүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгө ашиглалтгүй байгаа нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.2.10<sup>6</sup> дахь заалттай нийцэхгүй байна.

#### **Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:**

Мөрөн сумын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн хүрээнд бий болсон хөрөнгөд холбогдох шийдвэрийг гаргуулж, нягтлан бодох бүртгэлд тусгаж ажилласан байна.

Дээр дурдсан зөрчлүүдээс үзэхэд аймгийн Засаг дарга, ОНӨГ нь хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг хууль журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, барилга байгууламжид хийсэн засварын ажлыг стандартын капиталжуулах ажлыг хэрэгжүүлээгүй байгаа нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт алдагдах эрсдэлийг дагуулж байна.

**А.4. Сүүлийн 5 жилд хэрэгжсэн 11.7 тэрбум төгрөгийн 118 төсөл арга хэмжээний 52 хувь буюу 6.2 тэрбум төгрөгийн 61 төсөл, арга хэмжээ өмчлөлд бүртгэх боломжгүй, 9.3 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ үр өгөөжгүй хөрөнгө оруулалт болсон байна.**

Аймгийн төсвийн хөрөнгө 2020 оноос 2024 оныг дуустал 5 жилийн хугацаанд 11,738.4 сая төгрөгийн 118 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнээс 11,180.8 сая төгрөгийн төсөв өртөгтэй 113 төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан бол, 557.6 сая төгрөгийн 2024 онд хэрэгжиж эхэлсэн 5 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусаагүй байна.

Сүүлийн 5 жилд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг хөрөнгө оруулалтын төрлөөр ангилж үүнээс өмчлөл үүсгээгүй, ашиглалт хангалтгүй төсөл, арга хэмжээний тоо, үнийн дүнг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №5 /сая төгрөгөөр/

| Хөрөнгө оруулалтын төрөл | Төсөл арга хэмжээний тоо | Үнийн дүн       | Хөрөнгө үүсгэсэн эсэх |           | Хөрөнгө үүсгээгүй ТАХ-ний үнийн дүн | Ашиглалтгүй буюу үр өгөөжгүй төсөл, арга хэмжээний |                |
|--------------------------|--------------------------|-----------------|-----------------------|-----------|-------------------------------------|----------------------------------------------------|----------------|
|                          |                          |                 | тийм                  | үгүй      |                                     | тоо                                                | үнийн дүн      |
| Барилга, байгууламж      | 17                       | 3,287.9         | 17                    | -         | -                                   | 2                                                  | 70.9           |
| Засвар                   | 58                       | 6,953.6         | 9                     | 49        | 6,030.4                             | 5                                                  | 673.9          |
| Тоног төхөөрөмж          | 28                       | 1,268.7         | 27                    | 1         | 18.5                                | 4                                                  | 154.7          |
| Зөвлөх үйлчилгээ         | 5                        | 159.9           | 4                     | 1         | 79.9                                | 3                                                  | 122.6          |
| Дэмжлэг                  | 8                        | 39.2            | -                     | 8         | 39.2                                | 8                                                  | 39.2           |
| Бараа материал           | 2                        | 27.7            | -                     | 2         | 27.7                                | -                                                  | -              |
| <b>Дүн</b>               | <b>118</b>               | <b>11,738.4</b> | <b>57</b>             | <b>61</b> | <b>6,197.0</b>                      | <b>22</b>                                          | <b>1,061.3</b> |

<sup>6</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх;

Хүснэгтээс харахад 5,541.4 сая төгрөгийн 57 төсөл, арга хэмжээ буюу 48 хувь нь өмчлөл үүсгэж үлдсэн 6,197.0 сая төгрөгийн 61 төсөл, арга хэмжээ буюу 52 хувь нь өмчлөл үүсгээгүй бол 1,061.3 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ ашиглалтгүй, үр өгөөжгүй байна.

Тухайлбал:

1. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлж, амьдрах орчныг сайжруулах хөтөлбөр, арга хэмжээг 8 багцтайгаар хэрэгжүүлж иргэд, байгууллагуудад 39.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь энэ хэмжээгээрээ төсвийн хөрөнгө оруулалтыг үр өгөөжгүй болгосон байна.
2. Орон нутгийн төсвийн 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар Цагааннуур суманд цагаан загас үржүүлгийн судалгааны байр барих, тоног төхөөрөмж нийлүүлэх 2 төсөл, арга хэмжээг 35.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн боловч тухайн суманд мэргэжилтэй боловсон хүчингүй, урсгал зардлын санхүүжилтгүй зэргээс шалтгаалан одоо ямар ч ашиглалтгүй үр өгөөжгүй ажил болсон байна



3. Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар Бүрэнтогтох, Түнэл сумдад Малын гаралтай түүхий эдийн мөшгөх тогтолцоог хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 79.9 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн боловч ямар үр дүнд хүрсэн нь тодорхойгүй, нэг удаагийн нөлөөллийн шинжтэй арга хэмжээ хэрэгжүүлээд өнгөрсөн нь төсөл, арга хэмжээг үр өгөөжгүй болгож байна.
4. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар Түнэл суманд Хүндэтгэлийн өргөө барих 55.9 сая төгрөгөөр нь хэрэгжүүлсэн боловч хэрэгцээ шаардлагад тулгуурлаагүй хэрэгжүүлсэн тус төсөл ,арга хэмжээ нь байнгын ашиглалтгүй үр өгөөжгүй байна.
5. Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар Мөрөн сумын Баяр наадмын талбайн урд асрын засварын ажлыг 224.9 сая төгрөгөөр хийсэн боловч хадгалалт хамгаалалт муутайгаас хийгдсэн будаг замаск нь хуурч унасан, цонх хагарсан, сандлууд эвдэрсэн, өнгө үзэмж муутай болсон нь дахин хөрөнгө оруулалт хийх шаардлага үүсгэж, төсөл, арга хэмжээний үр өгөөжийг бууруулж байна.
6. Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар Аймгийн баяр наадмын талбайн хиймэл ногоон зүлэг, гүйлтийн зам засвар шинэчлэлтийн ажлыг 246.2 сая төгрөгөөр хийсэн боловч зүлгийг шинэчлэхгүйгээр дүүргэгч резин ашиглаж сайжруулалт хийсэн нь дахин зүлгийг шинэчлэх хөрөнгө оруулалт хийх шаардлага үүсгэж төсвийн үр ашгийг бууруулах эрсдэлтэй байна.
7. Баянзүрх суманд 2024 онд 20.0 төгрөгөөр 150 хүүхдийн дотуур байрны өрөөний засварын ажил нь түр хугацаанд хүүхдүүдийг байрлуулах боломж үүсгэж байгаа ч үндсэн байр нь өөрөө ашиглалтын шаардлага хангахгүй, хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл учруулах эрсдэлтэй байгаа нь төсөл, арга хэмжээний үр өгөөжийг бууруулж байна.

8. Мөрөн сумын Сод эрдэм 640 хүүхдийн сургуулийн дээврийн засварын ажлын зураг, төсвийг зохиолгож, батлахдаа дээврийн агааржуулалтыг дутуу тооцоолж, агааржуулалтын цөөн хоолойтой хийсэн нь дотоод агаар гадагшлахгүй эвгүй үнэр буцаж орж ирдэг нөхцөл байдлыг бий болгож төсөл, арга хэмжээний үр өгөөжийг бууруулж байна.
9. Шилжих хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлсэн Мөрөн сумын 8 дугаар хүүхдийн цэцэрлэгийн цэцэрлэгийн дээврийн их засварын ажлын 2025 оны гэрээнд заасан санхүүжилт 185.0 сая төгрөгийг төгрөгийг 2025 оны төсөв суулгаж өгөөгүй нь төсөл, арга хэмжээ үр ашиггүй, зогсонги байдалд орох эрсдэлийг үүсгэж байна.

Сүүлийн 5 жилд хэрэгжсэн 11.7 тэрбум төгрөгийн 118 төсөл арга хэмжээнээс 52 хувь өмчлөлд бүртгэх боломжгүй, 9.3 хувь нь үр өгөөжгүй хөрөнгө оруулалт болсон байна.

*Аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хууль, Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын дагуу хөрөнгө оруулалтыг төлөвлөөгүй, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтыг хянан, батлах чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаагаас, тайлант онд шинээр хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээ хуульд заасан шаардлагад нийцээгүй, сүүлийн 5 жилд хэрэгжсэн 11.7 тэрбум төгрөгийн 118 төсөл арга хэмжээний 52 хувь буюу 6.2 тэрбум төгрөгийн 61 төсөл, арга хэмжээ өмчлөлд бүртгэх боломжгүй, 9.3 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ үр өгөөжгүй хөрөнгө оруулалт болсон байна.*

## БҮЛЭГ Б:

**Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шалгуурыг хангасан гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж ажилласан байна.**

### **Б.1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын захиалагч нь тендер шалгаруулалтын баримт бичгийг баталгаажуулж ажиллаагүй байна.**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг шинэчлэн найруулж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Хуулийн шинэчилсэн найруулгад худалдан авах ажиллагааны үнэлгээний шинэ зохицуулалтыг хуульчилсан нь 100.0 сая төгрөг хүртэл үнийн дүн бүхий худалдан авах ажиллагаанд 3-аас доошгүй, 100.0 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авах ажиллагаанд 5-аас доошгүй үнэлгээний хорооны гишүүнтэй байхаар хуульчилсан байна. Дээрх шаардлагыг хянахад шууд худалдан авалт хийх ажлын хэсгийн гишүүдийг эс тооцвол худалдан авах ажиллагааны хуульд заасан үнийн дүн, гишүүдийн тоонд нийцүүлэн үнэлгээний хороог байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны явуулсан 68 үнэлгээний хороонд давхардсан тоогоор 256 үнэлгээний хорооны гишүүн ажилласан ба шууд худалдан авалтыг зохион байгуулсан ажлын хэсгийн гишүүдийг эс тооцвол бусад үнэлгээний хорооны гишүүд бүгд АЗ сертификаттай худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн хүмүүс ажилласан байна.

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/257, 258, 259, 260, 261, 262 дугаар тушаалуудаар дараах тендерийн жишиг баримт бичгүүдийг баталсан ба үнэлгээний хороод нь түүнд нийцүүлэн нийт 35 тендерийн баримт бичгийг боловсруулсан ба захиалагчаар батлуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1<sup>7</sup> дахь заалттай нийцэхгүй байна.

Мөрөн сумын тухайд худалдан авах ажиллагааны баримт бичгүүдийг баталгаажуулж ажилласан байна.

<sup>7</sup> Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.



Хууль заасны дагуу үнэлгээний хороог байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулсан хэдий ч худалдан авах ажиллагааны гол баримт бичиг тендер шалгаруулалтын баримт бичгийг захиалагчаар баталгаажуулж ажиллаагүй байгаа нь худалдан авалттай холбоотой маргаан гарах эрсдэлийг үүсгэж байна.

## Б.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна.

Тайлант онд аймгийн болон Мөрөн сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 6,165.8 сая төгрөгийн 68 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Худалдан авах ажиллагаа явуулсан байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 6 /сая төгрөгөөр/

| №    | Эх үүсвэр        | ХАА явуулсан ТАХ-ний тоо, төсөвт өртөг |         | Худалдан авах ажиллагаа явуулсан хэлбэр |       | Гэрээ байгуулсан ТАХ-ний тоо, гэрээний дүн |         | ХАА амжилтгүй болсон ТАХ-ний тоо төсөвт өртөг |         | Тендерийн хэмнэлт |
|------|------------------|----------------------------------------|---------|-----------------------------------------|-------|--------------------------------------------|---------|-----------------------------------------------|---------|-------------------|
|      |                  | тоо                                    | дүн     | Уламжлалт                               | Цахим | тоо                                        | дүн     | тоо                                           | дүн     |                   |
| 1    | Аймгийн ОНХО     | 35                                     | 4,896.7 | 7                                       | 28    | 29                                         | 3,069.4 | 6                                             | 1,778.7 | 48.5              |
| 2    | Мөрөн сумын ОНХО | 33                                     | 1,269.1 | 18                                      | 15    | 33                                         | 1,258.8 | -                                             | -       | 32.8              |
| Нийт |                  | 68                                     | 6,165.8 | 25                                      | 43    | 62                                         | 4,328.2 | 6                                             | 1,778.7 | 81.3              |

Аймгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон тендерийн хэмнэлтийг зарцуулаагүй бол Мөрөн сумын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон 32.8 сая төгрөгийн тендерийн хэмнэлтийг 2024 оны төсвийн тодотголоор шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжилтээр баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3<sup>8</sup> дахь заалттай нийцэхгүй байна. Зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

### Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 12 төсөл, арга хэмжээнд нээлттэй, 16 төсөл, арга хэмжээнд харьцуулалтын, 7 төсөл, арга хэмжээнд шууд худалдан авалтын аргыг хэрэглэсэн байна. Уламжлалт худалдан авах ажиллагааг шууд худалдан авалтуудад ашигласан байна. Худалдан авах ажиллагааны аргыг төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нийцүүлэн сонгон хэрэглэсэн байна.

Тайлант онд худалдан авах ажиллагаанд давхардсан тоогоор 82 удаагийн тендер шалгаруулалт зарлаж тендерт нийт 51 оролцогч оролцжээ. Худалдан авах ажиллагаанд нийтдээ 2,100 өдөр нэг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд дунджаар 60 өдрийг зарцуулсан байна.

Гэрээ байгуулагдаагүй амжилтгүй болсон худалдан авах ажиллагаанд 859 өдрийг зарцуулж 25 удаа зарлахад 3 төсөл, арга хэмжээний тендерт оролцогч оролцоогүй бол 3 төсөл, арга хэмжээний тендерт оролцсон 4 оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй байна.

Худалдан авах ажиллагааг зарлахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хугацааг огт баримтлаагүй 10-272 өдөр хүртэлх өдрөөр хоцорч зарласан байна. Энэ нь төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөөгүй, төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зарлаагүйгээс шалтгаалсан байна.

Тендер шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн тендерийн баримт бичигт хяналт хийхэд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан техник, туршлагын шаардлага,

<sup>8</sup> Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална: хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх;



санхүүгийн чадавхын шаардлага, чадавхын шаардлагыг хангасан гүйцэтгэгчдэд гэрээ байгуулах эрх олгож ажилласан байна.

**Мөрөн сумын хөрөнгө оруулалтын тухайд:**

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 2 төсөл, арга хэмжээнд нээлттэй, 13 төсөл, арга хэмжээнд харьцуулалтын 18 төсөл, арга хэмжээнд шууд худалдан авалтын аргыг хэрэглэжээ. Худалдан авах ажиллагааны аргыг төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нийцүүлэн сонгон хэрэглэсэн байна.

Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтын 33 төсөл, арга хэмжээнд давхардсан тоогоор 52 удаагийн тендер шалгаруулалт зарлаж тендерт нийт 71 оролцогч оролцсон байна. Худалдан авах ажиллагаанд нийтдээ 500 өдөр зарцуулж дунджаар 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд 15 өдрийг зарцуулсан байна.

Худалдан авах ажиллагааг зарлахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хугацааг баримтлаагүй 4-272 өдөр хүртэлх өдрөөр хоцорч зарласан байна. Энэ нь төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөөгүй, төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зарлаагүйгээс шалтгаалсан байна.

Тендер шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн тендерийн баримт бичигт хяналт хийхэд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан техник, туршлагын шаардлага, санхүүгийн чадавхын шаардлага, чадавхын шаардлагыг хангасан гүйцэтгэгчдэд гэрээ байгуулах эрх олгож ажилласан байна.

Хууль, тогтоомжийн мөрдөлттэй холбоотой дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Мөрөн сумын хөрөнгө оруулалтын Хилийн цэргийн 0257 дугаар ангиас 2 дугаар хорооны авто зам хүртэлх явган замын тохижилт, шинэчлэлт төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Мөнх өсөн нэмэх” ХХК-тай тендерийн хүчинтэй хугацаа болон гэрээ байгуулах тухай мэдэгдэлд заасан хугацаанд гэрээг байгуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 30 дугаар зүйлийн 30.1<sup>9</sup>, 41 дүгээр зүйлийн 41.1.5<sup>10</sup> дахь заалтуудтай нийцээгүй илт хууль бус гэрээгээр ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Дээрх зөрчлийг эс тооцвол худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн явуулсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлаагүй, тендер шалгаруулалтын баримт бичгийг баталгаажуулж ажиллаагүй боловч тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажилласан байна.

**БҮЛЭГ В:**

**Барилга байгууламж засварын ажлын бүх талын хяналтын үр нөлөөг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага үүссэн байна.**

**В.1. Барилга байгууламж, засварын ажлын бүх талын хяналтын үр нөлөөг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага үүссэн байна**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламж, засварын төсөл, арга хэмжээнүүдэд тавих хяналтыг гэрээний үндсэн Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв, болон зураг, төсөв зохиогч, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хяналт хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авах ажлыг аймаг, сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан комисс /аймгийн хөрөнгө оруулалтын тухайд Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраар ахлуулсан/ хэрэгжүүлж ажилласан байна.

Харин тоног төхөөрөмжийн хувьд захиалагч болон хүлээн авагч байгууллагаас томилогдсон ажлын хэсэг хяналт хийх, хүлээн авах ажлыг хэрэгжүүлсэн байна.

<sup>9</sup> Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар, эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ.

<sup>10</sup> Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: тендер хүлээн авах эцсийн хугацааг, эсхүл энэ хуулийн 30.1-д заасан гэрээ байгуулах хугацааг баримтлаагүй

Хөвсгөл аймгийн хөрөнгө оруулалт/ барилга байгууламж/-д хийгдэх хяналтын тогтолцоог дүрслэлээр үзүүлбэл дараах байдалтай байна. Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, журам, дүрэмд дүн шинжилгээ хийхэд дээрх тогтоолцоо нь хяналтын зохицуулалтуудтай нийцэж байна.

Дүрслэл №1



Хууль, дүрэмд заасны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын барилга байгууламж, засварын ажилд олон талын хяналт хэрэгжиж байгаа боловч аудитаар төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Музей, Номын сангийн байрны сантехникийн засвар төсөл, арга хэмжээг Хөвсгөл Мичид ХХК 199.5 сая төгрөгөөр гүйцэтгэхдээ ган радиатор/8 секцтэй паар/ 38 ширхгийг суурилуулах байснаас 22 ширхгийг суурилуулж 16 паар суурилуулаагүй, халаалтын хоолойнуудын холболтуудыг холбох хэрэгсэл ашиглалгүй шууд гагнаж холбосон байна. Үүнд Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.




Халаалтын хоолойнуудын холболтуудыг холбох хэрэгсэл ашиглалгүй шууд гагнаж холбосон байдал

2. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Биеийн тамир, спортын газрын заалны их засвар төсөл, арга хэмжээг Энх халиун сервис ХХК 292.3 сая төгрөгөөр гүйцэтгэхдээ шалны ажлыг зохиогчийн зөвшөөрөлгүй өөрчилж, коридорын тааз ханыг хусаж цэвэрлээгүй өнгөлгөө замаск хийж тэгшлэлгүй будсан, шалны ажлын лак өнгөлгөө хангалтгүй /эсвэл нимгэрсэн/ байна. Үүнд Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв, зураг, төсөв зохиогч хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.



*Биеийн тамир, спортын газрын 2 давхрын коридорын таазыг эмальсдсэн байдал, шалны ажлын гүйцэтгэл*

3. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Аймгийн Баяр наадмын талбайн хиймэл ногоон зүлэг, гүйлтийн зам засвар шинэчлэлт төсөл, арга хэмжээг Эйч Би Эс ХХК 250.0 сая төгрөгөөр гүйцэтгэхдээ гүйлтийн замын ажлыг өнгө үзэмжгүй хавтан хоорондын амлагаа болон хуучин зам хоорондын амлагааг жигд түвшинд хийгээгүй, тэгш хэмгүй /овон, товон/ хийсэн байна. Үүнд Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.



*Аймгийн Баяр наадмын талбайн гүйлтийн замын амлагааг тэгш хэмгүй, гүйлтийн замыг овон товон хийсэн байдал*

4. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Хүүхдийн цэцэрлэгийн дээврийн их засвар /Мөрөн сум 8-р баг 8 дугаар цэцэрлэг/ төсөл, арга хэмжээг Бунбах ХХК 141.2 сая төгрөгөөр гүйцэтгэхдээ ханын доод хаяавч хэсгийг битүүлээгүй, дээврийн гарнизны хэсэг нь хийцэл муутай, дээврийн хэсэг нь зарим хэсгээрээ ханын дулаалгатай хэт ойртсон байгаа нь гоёлын өлзий хээтэй төмөр булан байрлуулах зайгүй болгосон, мөн цонх болон сайдинг хоорондын зайг битүүлээгүй, цонхны хаялга төмрийг зарим цонхонд хийгээгүй, барилгын хойд хэсэгт байшингийн суурь хэсгээс ургасан модыг авалгүй дулаалгыг тойруулж хийсэн байна. Үүнд Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.





Мөрөн сумын 8 дугаар цэцэрлэгийн дээврийн гарнизны хэсэг болон гадна сайдинг хийсэн байдал

5. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Эрдэнэбулган сумын Сумын төвд нэгдсэн халаалт холбох байгууллагын дотоод сантехникийн их засвар төсөл, арга хэмжээг Их хорьдол групп ХХК гүйцэтгэхдээ гэрээнд заасан 2024.05.10 - 2024.12.25 хугацаанд хийж дуусгаагүй байна. Үүнд Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
6. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Хатгал тосгоны Ерөнхий боловсролын бага сургуулийн засвар, дулаалга, Хатгал тосгоны Ерөнхий боловсролын бага сургуулийн засвар, дулаалга, Арбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын дулаалга засвар төсөл, арга хэмжээнүүдийг гүйцэтгэхдээ аянга зайлуулагчийг хийгээгүй /эсхүл дулаалгын хөөсөнцөр хавтанг гадна талаас нь шууд тогтоосон/ байна. Үүнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын комисс хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.



Хатгал тосгоны Ерөнхий боловсролын бага сургуулийн засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэхдээ газардуулгыг таслаад эргэж холбоогүй байдал



Хатгал тосгоны Ерөнхий боловсролын бага сургуулийн засвар, дулаалга ажлыг гүйцэтгэхдээ газардуулга хийгээгүй байдал

Дээрх зөрчлүүд нь Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5<sup>11</sup>, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.11<sup>12</sup>, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны А/178 дугаар тушаалаар баталсан "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм"-ийн 3.1<sup>13</sup>, баталсан Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-

<sup>11</sup> Барилгын асуудал эрхэлсэн төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь барилгын үйл ажиллагаанд холбогдох норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих замаар хувийн, нийтийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ

<sup>12</sup> Захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

<sup>13</sup> Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай / цаашид захиалагч гэх/ гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина.

ийн 5.1.3<sup>14</sup>-т заасан чиг үүргээ хяналтын чиг үүрэг бүхий байгууллагууд хангалтгүй хэрэгжүүлснээс шалтгаалан гарсан байна.

Олон талын шат дараатай хяналт хэрэгжиж байгаа боловч барилгын ажлын гүйцэтгэл зарим талаар хангалтгүй байгаа нь тогтолцооны гэхээсээ илүү хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд нь үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлэхгүй байгаагаас шалтгаалсан байна гэж үзэх нөхцөл болж байна.

Хяналтын ажилд зарцуулж байгаа зардлын байдлыг харуулбал тайлант онд дараах байдалтай байна. Үүнд:

1. Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвд тайлант онд аймгийн төсвөөс 225 сая төгрөг, Мөрөн сум төсвөөс 14.9 сая төгрөг нийт 239.9 сая хяналтын зардал олгосон байна.
2. Зохиогчийн хяналтад аймгийн төсвөөс 33.7 сая төгрөг, Мөрөн сумын төсвөөс 7.3 сая төгрөг нийт 41.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
3. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Улсын комисс ажиллуулах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас олгоогүй байна.

Төрийн аудитын газраас 2025 гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгээс үзэхэд захиалагч болон зохиогчийн хяналтын зардлын зарцуулалттай холбоотой дараах анхаарал татсан дараах асуудлууд байна. Үүнд:

1. Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ нь 2024 онд 11 ажилтанд 238.1 сая төгрөгийн цалингийн зардал олгосон боловч үүнээс 6 ажилтан л хяналт хэрэгжүүлэх мэргэжил, мэдлэгтэй байгаа нь цалингийн зардлын 40 орчим хувь нь үр ашиггүй зарцуулагдсан болохыг харуулж байна.
2. Монголын цахилгаан холбооны байранд байр түрээсэлсний төлбөрт 8.1 сая төгрөг зарцуулсан байна.
3. Зохиогчийн хяналтын 33.7 зардлыг олгохдоо зохиогчийн хяналтын тэмдэглэлүүдгүй, гэрээ дүгнэсэн актгүй олгосон байна.

Дээрх байдлаас харахад захиалагчийн хяналтын зардал нь зөвхөн Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын үйл ажиллагааны зардал болж байгаа бол зохиогчийн хяналтын зардал нь ямар ч үр нөлөөгүй, хяналт хийгдээгүй байхад олгогддог зардал болсон байна.

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвийн боловсон хүчин нь Засгийн газрын 2021 оны 343 дугаар тогтоолоор баталсан “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам”-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт хяналт хийхэд дараах шаардлагуудыг хангахгүй байна. Үүнд:

1. Мэргэжлийн 9 инженерээс дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер, ус хангамж, ариутгах татуургын инженер, барилгын эдийн засагч-төсөвчин, барилгын материалын үйлдвэрийн технологич инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан гэсэн 3 мэргэжлийн инженер, 2 мэргэжлийн ажилтангүй байна.
2. Одоо ажиллаж байгаа боловсон хүчин нь журамд заасан хяналтын инженерүүд нь мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан байх, зөвлөх зэрэгтэй байх мэргэжлийн зэргийн болон туршлагын шаардлагыг хангахгүй байна.

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-д шаардлагатай боловсон хүчин дутагдалтай, мэргэжлийн зэрэг, туршлагын шаардлагыг хангахгүй байгаа нь захиалагчийн хяналтын үйл ажиллагааг цаашид мэргэжлийн түвшинд явуулж чадах эсэхэд эргэлзээг төрүүлж байна.

Аудитаар цугларсан баримтаас үзэхэд захиалагчийн хяналтын төв нь үе шатны хяналтыг хэрэгжүүлдэггүй, хяналтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтээ эргэж хянадаггүй, амаар

<sup>14</sup> Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх;



үүрэг даалгавар өгдөг, хяналтын ажлын баримт бүрдүүлж ажиллахгүй байгаа зэрэг нь хяналтын үр нөлөөг сулруулсан, хариуцлагагүй байдал бий болсныг илтгэж байна.

Өмнөх онуудад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн аудитуудаар гарч байсан зөрчил тайлант онд давтагдан гарсан, захиалагчийн хяналтын зардал зарим талаар үр ашиггүй зарцуулагдсан, туршлага, мэргэжлийн зэрэгтэй боловсон хүчингүй байгаа зэргээс харахад 2020 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ нь цаашид үнэхээр үр нөлөөтэй байж чадах эсэхэд дүгнэлт хийх цаг болсныг харуулж байна.

Захиалагчийн хяналтаас гадна зохиогч нь цаг тухай бүр тэмдэглэл үйлдэж хяналт хэрэгжүүлдэггүй, зураг, төсөвт өөрчлөлт орох тохиолдол бүрд хяналт хийж зөвшөөрөл өгдөггүй, ажил хийгдэж дууссаны дараа энэ тухай дүгнэлт гаргаж санхүүжилт авсан тохиолдол цөөнгүй байна. Жишээ нь:

1. Биеийн тамир, спортын газрын заалны их засварын ажлын шалны ажил зурагт зааснаас өөрчлөгдөж байхад зохиогч зөвшөөрөл өгөөгүй/холбогдох боломжгүй байсан/, ажил хийгдсэний дараа дүгнэлт өгсөн байна.

7. Зохиогчийн хяналтын явцад батлагдсан зураг төслөөс өөрчлөгдсөн асуудлыг тодорхой бичиж, зохиогчийн зүгээс өөрчлөлтийг батлагаажуулсан талаар тэмдэглэх:

Барилгын засвар: Барилгын шал засварлах ажилд зориулалтын шалыг резинэн будгаар будах мөн коридорт хулдаасан шал дэвсэхээр төлөвлөснийг /барилгын зориулалтын шалны үнэ төсөвт багаар тусгагдсан, талбай дээр резинэн будаг хийх шаардлагагүй, хулдаас дэвсэх шаардлагагүй/ хасаж, захиалагч, гүйцэтгэгч харилцан зөвшилцөж өөрчилсөний үндсэн дээр зориулалтын шалыг стандартад нийцсэн өндөр үнэтэй шалаар солих өөрчлөлт хийгдсэн байна.

*Зураг, төсвийн зохиогч Итгэлт чандмань ХХК-ийн дүгнэлтийн хэсгээс*

Харин аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс хөрөнгө оруулалтад хяналт хийж тайлангуудыг ирүүлж ажилласан байна.

*Дээр дурдсан нөхцөл байдлуудаас үндэслэн аймгийн Засаг дарга нь барилга байгууламж засварын ажлын бүх талын хяналтын үр нөлөөг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах зайлшгүй шаардлага үүссэн байна гэж дүгнэлээ.*

**В.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

Төрийн аудитын газраас 2024 онд гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой 4 албан шаардлага, 6 зөвлөмжийг 6 албан тушаалтанд хүргүүлж албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хүлээн авч хэрэгжилтийг тооцож ажилласан. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмж болон аудитаар илэрсэн зөрчлийг харьцуулбал дараах байдалтай байна.

*Хүснэгт № 7*

|   | Албан тушаалтан       | Аудитын шийдвэр | Утга                                                                                              | Аудитын илэрсэн асуудал                                                                                                                                                                                             |
|---|-----------------------|-----------------|---------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Аймгийн ИТХ-ын даргад | Албан шаардлага | Төлөвлөлтийн шаардлага хангаагүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ баталдаг зөрчлийг арилгах | Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 4,133.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээ нь хууль, журамд заасан төлөвлөлтийн шаардлагуудыг бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээнүүдийг баталсан байна. |

|   |                                                                         |                 |                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                        |
|---|-------------------------------------------------------------------------|-----------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2 | Аймгийн Засаг даргад                                                    | Албан шаардлага | Төлөвлөлтийн шаардлага хангаагүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөдөг зөрчлийг арилгах                                                         | Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 4,133.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээ нь хууль, журамд заасан төлөвлөлтийн шаардлагуудыг бүрэн хангаагүй байна. Жишээ нь: Олон нийтээр нийт хөрөнгө оруулалтыг хэрэлцүүлээгүй байна.                  |
|   |                                                                         | Зөвлөмж         | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах                      | Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 440.5 сая төгрөгийн хөрөнгийг өмчид бүртгэх холбогдох өмчид бүртгүүлээгүй, УСНББОУС-ын дагуу үнэлэн капиталжуулах ажлыг 1,004.7 сая төгрөгийн 7 засварын ажилд зохион байгуулаагүй байна |
| 3 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад                               | Зөвлөмж         | Төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтын төлөвлөж ажиллах;                                                                                        | Хөрөнгө оруулалтыг хууль журамд нийцүүлэн төлөвлөж ажиллаагүй байна.                                                                                                                                                                                                   |
|   |                                                                         |                 | Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн чиг үүргийг тодорхой болгож, ажлын уялдааг хангах                                                                    | Аймгийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байна. Тухайлбал: ОНӨГ хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл муутай байгаа нь өмч бүртгэлийн асуудалд нөлөөлсөн байна.                                                                                        |
| 4 | Орон нутгийн өмчийн газрын даргад                                       | Зөвлөмж         | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах үр өгөөжийг сайжруулах; | Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 440.5 сая төгрөгийн хөрөнгийг өмчид бүртгүүлээгүй, УСНББОУС-ын дагуу үнэлэн капиталжуулах ажлыг 1,004.7 сая төгрөгийн 7 засварын ажилд зохион байгуулаагүй байна                         |
| 5 | Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга | Албан шаардлага | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын техникийн тодорхойлолт, гэрээг чиг үүргийн хэлтэс боловсруулаагүй зөрчлийг арилгах                             | Хөрөнгө оруулалтын техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс боловсруулж ажилласан байна.                                                                                                               |
|   |                                                                         | Зөвлөмж         | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн төлөвлөх                                              | Хөрөнгө оруулалтыг хууль журамд нийцүүлэн төлөвлөж ажиллаагүй байна.                                                                                                                                                                                                   |
| 6 | Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захиралд             | Албан шаардлага | Захиалагчийн хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах                                                                                                   | Аудитаар илэрсэн зөрчлөөс үзэхэд захиалагчийн хяналтын чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.                                                                                                                                                                       |
|   |                                                                         | Зөвлөмж         | Гэрээний хугацаанд дуусаагүй төсөл, арга хэмжээнүүдийн зөрчлийг арилгуулах, захиалагчийн хяналтын үр нөлөөг сайжруулах;                                     | Тайлант онд 2 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаа хэтэрсэн, 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байдалтай байна.                                                                                                                                              |

Хүснэгтэд үзүүлснээр өмнөх онд гүйцэтгэсэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, барилга байгууламж, засварын ажилд тавих бүх талын хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байгаа нь аймгийн Засаг даргаас энэ талаар арга хэмжээ авч, аудитын шийдвэрийн хэрэгжилт, захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр нөлөөг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

**Аудитаар нийт 7,986.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчил арилгах 2 албан шаардлага, 2,048.7 сая төгрөгийн 21 зөвлөмжийг 7 байгууллага, албан тушаалтанд өгч ажиллалаа.**

## АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймгийн Засаг дарга нь хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөх, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг хянан, батлах чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байна.
2. Төсөвлөлтийн шаардлага хангасан, хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалтыг хуваарилж зарцуулахгүй байгаагаас байгаагаас сүүлийн 5 жилд хэрэгжсэн 11.7 тэрбум төгрөгийн 118 төсөл арга хэмжээний 52 хувь буюу 6.2 тэрбум төгрөгийн 61 төсөл, арга хэмжээ өмчлөлд бүртгэх боломжгүй, 9.3 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ үр өгөөжгүй хөрөнгө оруулалт болсон байна.
3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлаагүй, тендер шалгаруулалтын баримт бичгийг баталгаажуулж ажиллаагүй боловч тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шалгуурыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажилласан байна.
4. Ашиглалтад хүлээн авсан 3 төсөл, арга хэмжээний 440.5 сая төгрөгийн хөрөнгийг өмчид бүртгүүлээгүй, УСНББОУС-ын дагуу үнэлэн капиталжуулах ажлын 1,004.7 сая төгрөгийн 7 засварын ажилд зохион байгуулаагүй байгаа нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт алдагдах эрсдэлийг дагуулж байна.
5. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 67 хувь, Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтын 92 хувийг хэрэгжүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн ба аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл өмнөх онтой харьцуулбал 22 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
6. Төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байгаа нь аймгийн Засаг даргаас энэ талаар арга хэмжээ авч, аудитын шийдвэрийг хэрэгжилт, захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр нөлөөг сайжруулах, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.



## **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:**

### **Аймгийн Засаг дарга(Л.Төмөрбаатар)-д:**

1. Өмчлөлд бүртгэх боломжгүй, урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын төсөвт шилжүүлэн батлуулж байх.
2. Захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр нөлөөг сайжруулж, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх

### **Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Базардамбуу)-д:**

1. Гэрээний хугацаа хэтэрсэн Сумын төвд нэгдсэн халаалт холбох байгууллагын дотоод сантехникийн их засвар /Эрдэнэбулган сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид алданги тооцох

### **Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга(Л.Баярхүү)-д:**

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хууль, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу төлөвлөж

### **Мөрөн сумын Засаг дарга(Х.Тайванбаяр)-т:**

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хууль, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу төлөвлөж , олон нийтээр хэлэлцүүлж байх,
2. Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах.
3. Өмчлөлд бүртгэх боломжгүй, урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын төсөвт шилжүүлэн батлуулж байх
4. Худалдан авах ажиллагааны тендерийн хүчинтэй хугацаанд гэрээ байгуулж ажиллах,
5. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон тендерийн хэмнэлтийг зарцуулахгүй байх.
6. Мөрөн сумын 10, 13, 14 дүгээр багуудын гэрлэн хаяг төсөл, арга хэмжээний гэрээнд заасан барьцаа хөрөнгө 0.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, гэрээний дагуу чөлөөлөх.

### **Орон нутгийн өмчийн газрын дарга(Ц.Бэхбаяр)-д:**

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг шуурхай зохион байгуулж, хяналтыг хэрэгжүүлэх

### **Хөвсгөл аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга(Э.Аззаяа)-д:**

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийг баталгаажуулж ажиллах,
2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, төлөвлөгөөг баримталж ажиллах,
3. Захиалагч болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдлыг бодитоор үнэлж байж санхүүжилтийг олгох

### **Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга(Б.Ганзориг)-т:**

1. Төсөл, арга хэмжээний зураг, төсөв, ажлын иж бүрэн байдалд хяналт хэрэгжүүлж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулахад анхаарч ажиллах

### **Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал(Д.Батчулуун)-д:**

1. Тайланд дурдсан төсөл, арга хэмжээнүүдийн дутуу болон хангалтгүй хийгдсэн ажлуудыг гүйцэтгүүлж, захиалагчийн хяналтын үр нөлөөг сайжруулах,
2. Захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгчийн хувьд зохиогчийн хяналтыг үр нөлөөтэй болгох арга хэмжээ авах,
3. Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын дутуу орон тоог нөхөж ажиллах

### Зөрчлийн жагсаалт:

/сая төгрөгөөр/

